

УРАНСАЙХНЫ ШҮҮМЖ ХААШАА ЯВАХ ЁСТОЙ ВЭ?

Д. Цэнджав *

Сүүлийн 20 гаруй жил утга зохиолын шүүмж байгаа ч юм шиг, байхгүй ч юм шиг, хэрэгтэй ч юм шиг, хэрэггүй ч юм шиг, ашигтай ч юм шиг ашиггүй ч юм шиг сонин байдалтай явж ирлээ. Урансайхны шүүмжийн нийгмийн үүрэг гэж ярихаа болив. Юу гарч, хэрхэн хүлээж авах нь дур зоргын хэрэг болжээ. Шүүмж хөрснөөс арчигдсанд баяр хүргэе гэж хашгирч байсан ч “Түрүүлж дуугарсан хөхөөний ам хөлдөнө” гэдгийн үлгэрээр тэрхүү лут эрхмийн хүссэнээр болсонгүй. Дуу сулхан боловч шүүмж мөхөөгүй, тасалдангуй боловч хэлдгээ хэлээд л ирэв. 30, 40, 50-иад онд урансайхны шүүмжийг хүмүүсийн зан харилцаанд үүсдэг маргаан хэрүүл шиг ойлгож мушгин гуйвуулах, буруу ташаа ойлгох гөрдөх, дур зоргоор аашлах, жадлан эсэргүүцэж үгүйсгэх, дайран давшлах, гутаах доромжлох явдал бишгүй байв. “Урансайхан” гэдэг үгийн учрыг ойлгосонгүй. Энэ бол урлаг, энэ бол ухаан, энэ бол ухаан дотроо шинжлэх ухаан юм гэдгийг тоохгүй хэн ч хэнийг дайран шүүмжилж болно гэсэн “Обломов маягийн алхайрал” лугаа “Но.Данзантан маягийн завхрал” байв. Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен зэргийн үндэстэний сэхээтнүүд “Оюуны тамын тогоонд чанагдаж” байсныг үе үе санаж яасан ч цагаа олж төрөөгүй, яасан ч их тэвчээр вэ? гэж гасалмаар санагддаг.

Урансайхны шүүмжийг ийнхүү урлаг, соёл, танин мэдэхүй, гэгээрэл, сэтгэлгээ, гүн ухаан, тайлал зүй гэдгийг ойлгохгүй, ойлгосон ч ойлгохыг хүсэхгүй байсан явдал жараад оноос мэргэшиж Л.Түдэв, М.Гаадамба, Ц. Мөнх, Д.Цэнд, Ц.Хасбаатар, С.Лувсанвандан нарын зэрэг эрдэм боловсролтой, тал бүрийн чадалтай, ном үзэж нүд тайлсан сэхээтнүүд утгазохиолын үнэт зүйлсийн нэг болгож чадсан юм.

Шүүмж арчигдаж алга болох биш, арга хэлбэрээ өөрчилж, учраа олж шинээр төрөх янзтай. Ерээд оны сүүл, хоёр мянгаад оны эхээр цөөнгүй ном бүтээлүүд гарч, энэ тухайд танигдаж мэдрэгдэж яваа залуу эрдэмтэд болох шүүмжлэгч Д.Цэвээндорж, П.Батхуяг, Д.Мөнх-оргил нар урансайхны шүүмжлэлийн шинэ зууны өнгийг тодорхойлж байна. Цаана нь цөөнгүй эрдэмтэн залуус энэ чиглэлийг сонгон сонирхож, ид бичиж байна. Ер нь судлал шүүмжлэлийн нэгэн бүхэл үе залгамжлан гарч ирсэн нь сайхан хэрэг. Шүүмжид хайртай дуртай хүн ховор ч, зайлшгүй хэрэгтэйг хэн хүнгүй зөвшөөрдөг. Ер нь урансайхны шүүмжлэлийн ертөнцөд Ц.Хасбаатар гуай цөөн үгээр айхтар хатгаад хэлчихдэг хүн байсан. Тэрбээр “Ер нь шүүмжлэл гэдэг хачин мэргэжил. Өнгө булаалддаг даавуу шиг нэг харахад шүүмжлэгч байснаа, нэг мэдэхэд шүүмжлүүлэгч болчихсон байх нь олонтаа. Алдвал шүүмжлүүлнэ, алгуурлавал

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Утга зохиолын тэнхим

шүүмжлүүлнэ, магтвал шүүмжлүүлнэ, матвал шүүмжлүүлнэ” гэж сүрхий нүдийг нь олоод хэлчихжээ.

Монголын урансайхны шүүмжид алдаа ч бий, гавъяа ч бий. Өнгөрсөн үед шүүмж огт байхгүй байсан бол “алтан үеийнхэн” гэгдэх олон алдартан хэзээ очиж танигдах байсан бол, өнөөгийнхөн шиг өөр зуураа л ярилцахаас хэтэрэхгүй ч байсан магад. Шүүмж дан ганц харлуулдаггүй зохиолчдыг тосч авдаг, гаргаж ирдэг, тодруулдаг, алдаршуулдаг, төлөвшүүлдэг “шүүлтүүрийн ордон” байсан. Их авъяас ичимхий дальдрамхай, бүрэг байдаг. Хэн ч мэдэхгүй олон зохиол, шүлгийг шүүмжлэгчид л задалж шинжилж дээшээ татаж гаргаж ирсэн.

Бас шүүмжлэгчид гэдэг одоогийнхны хэллэгээр тийм чиг мангуу тэнэгтээ тулсан хүмүүс байгаагүй. Зэгсэн сэхээтэнлиг, олон юмыг урьтаад харчихдаг, төсөөлөл буй болгочихдог, орос өрнөдтэй харьцуулаад үзчихдэг, оюунлаг бүлэг хэсэг байсан. Шүүмжлэгчдэд нэг давуу тал бий. Тэр нь хөрвөх чадвар юм. Нийгмийн өөрчлөлтийн дараа тэр дороо хөрвөж утга зохиолын онолч, судлаач, эрдэмтэн, их дээд сургуулиудын профессор, нэртэй зохиолч, яруу найрагч болоод явчихсан. Тэд байраа олоод ер алзаагүй ч гэсэн, их утга зохиол хохирч үлджээ.

Уламжлалгүй шинэчлэлийг ертөнцөөс эрээд олохгүй. Мөнхөд тоосго, чулуу хоёр байсан, түүгээр л барилга байшин барьсаар ирсэнтэй адилхан юм. Харин гурвалжин, дөрвөлжин, дугуй гээд янз бүрийн хэлбэртэй л болсон байх. Мөнхөд дугуй байсара ирсэн. Дэлхийн чухал нээлтийн нэг дугуйг олсон явдал. Дугуйн хэлбэр өөрчлөгдсөн ч гадаргуунд өнхрөх мөн чанарыг хэн ч өөрчилж чадаагүй, чадах ч үгүй биз. Ганц дугуйгаар машин хөдлөхгүйн адил ер ганцхан “шинэчлэл” гэж яриад монгол утга зохиол хаа ч хүрэхгүй. Шинэчлэл гэдэг ороомог зүйл. Хуучин байдал эргээд хамгийн гайхалтай шинэчлэл болж хувирах зүй тогтол ч буй. Шинэ гэж ярьж байгаа юм ч маш хуучин юм байх явдал байна. Ер нь уран сайхны шинэчлэл ч юмуу, төөрөгдөл ч юмуу эцэстээ мэдэхээ, ойлгохоо болив бололтой.

Бидний ад үздэг социалист реализм зохиолчдыг утга далдлах гүн ухаан, ил биш билгүүн нүд, адтай ёжтой заль билэгт сургасан юм. Хэрвээ ийм байгаагүйсэн бол, наад зах нь Б.Явуухулан:

“Миний өвгөд дээдсийн морины туурайд наалдсан

Хүний нутгийн шороог ариун усаараа угаасан” гэж хэлж амжихгүй ч байсан магад. Үүгээр тэр үеийн “үзэл суртлын гал тогоочид” “хуурга” хийж чадахгүй.

Бишгүй л ахмад шүүмжлэгчидтэй уулзаж явсан, тэдний юу ярихыг сонсч явсан. “Социалист реализм гэгч зохиол бүтээлийн чөлөөт сэтгэлгээнд саад тотгор болж байна, шидэт реализм, романтизм хэрэгтэй, янз янзын сэтгэлгээ орж ирэх нь чухал, ширүүн реализм гэж нэг юм байна, зөрчилгүйн онол уран сайхны сэтгэлгээг чөдөрлөж байна гэх зэргийг дуулахын дээдээр дуулж, мэдэхийн дээдээр мэдэж байсан, ойлгохын дээдээр ойлгож байсан, ярилцахын дээдээр ярилцаж байсан. Робинзон шиг гав ганцаараа таслагдаж, арал дээр шүүмжлэгчид хаягдаагүй. Олон улсын шүүмжлэгчдийн холбоонд элсэж, тэндээс янз бүрийн санаа, онол, урсгал чиглэл олж авчирдаг байжээ. Үнэнийг хэлээд түүний ард хэн гарах билээ. Толгой дээр нэг намын үзэл суртлын заазуур цавчихад бэлэн байлаа. Үзэл суртлыг догма болгож, үзэл сурталчийн нүдээр харж, зохиолч найрагчдын чөлөөт сэтгэлгээнд саад болж байсан үе ч бий. Үнэндээ цөөнгүй шүүмжлэгч утга зохиолын соён гэгээрүүлэх үүргийг гүйцэтгэж, зохиогчдод болоод уншигчдад ихээхэн тус дэм болж байсан үед бий. Бас хувийн атгаг үзлээр хандаж, мушгин гуйвуулж, юм л бол өө сэв эрж, зохиолчийн хэмжээнд хүртэл ойлгохгүй дураар

эзэгнэсэн явдал ч байгаа. Ямар ч байсан хэн нь сайн, хэн нь тааруу вэ? өнөөгийн монголын уран зохиол хаана явна вэ? гэдэг баримжааг хэлээд ялгаад өгчихдөг байжээ. Бас утга зохиолын онол, хурц маргаан, мэтгэлцээн дундаас зохиолчид өөрийгөө олж хардаг болсон байв. Нэг чанартай шүүмж бусдад зэгсэн сургамж, хичээл болно. Өөрөө шүүмжлүүлсэн шиг санаа авна. Шүүмжлэгч залуу авьяастанг гаргаж ирдэг, дэмждэг, зохиолчдын нэр төрийг хамгаалдаг, цаашдын шинэ хандлагыг мэдрээд хэлчихдэг тийм л зиндаанд ажиллаж байв. Цөөн ч гэлээ, зохиолч улстөрийн юмуу, үндэсний үзэлтний далайн давалгаанд өртөхөд “аврах цамц” болж байсан.

Юмыг сайн талаас нь харвал сайхан л харагдана, муу талаас нь харвал муухай л харагдана. Ядаж голч дундачийг олж харах нь хөгжилд хэрэгтэй, зөв төлөвшилд хэрэгтэй. Өмнөхөө бишгүй шүүмжиллээ, одоо өнөөдрийг харцгаая л даа. Өнөөдөр шүүмж хэрэгтэй юу? гэж олонтаа асуужээ. Шүүмжлэгч, судлаачид ийм асуулт тавиад өөрсдөө хариулсан байна. Утгазохиолын шинэчлэгч сэтгэлгээт, онолчийн нэг эрдэмтэн Ч.Билэгсайхан яг ийм асуултад “Мэргэжлийн уран зохиолын тухайд хурц үнэн шүүмжлэл хэзээ хэнд хэрэгтэй тухайд дэлхий даяар гэж хэлэхэд ч болохоор тогтсон зарчим бий. Үүнд нэгд, Үнэхээр авьяас билэгтэй зохиолч муу зохиол бичвэл хоёрт, Огт дэмий хэрэггүй юм биччихээд өөрийгөө мундаг юм хийчихлээ гэж бодсон хуурмаг зохиолчдод үнэнийг нь шулуухан хэлэх. Энэ хоёр тохиолдолд шүүмж нэн тустай” гэжээ. Энэ нь В.Вульфийн “Сайн юмыг хайрлая гэвэл муу юмыг чин сэтгэлээсээ жигшин үзэх хэрэгтэй” гэсэн үгтэй агаар нэгэн байна. Бас хүмүүн төрөлхтний урлаг, утгазохиолыг үзэх идеалист онолыг үндэслэгчийн нэг Платон “Бид домог бүтээгчдийг анхааралтай хянаж байх хэрэгтэй. Бүтээл нь сайн бол хүлээн зөвшөөрч дэлгэрүүлэгчтүн. Муу бол бүү дэлгэрүүл” (Д.Галбаатар “Уран зохиолын нэвтэрхий толь” 162-р тал) гэсэн байна. Бас л жишээ авья. Манайхны орчуулж гаргасан Р.Уэллек, О.Уоррен нарын “Уран зохиолын онол” (1998) номонд “Уран зохиолын онолыг шүүмжлэл түүхгүйгээр, шүүмжлэлийг түүх онолгүйгээр, түүхийг онол шүүмжлэлгүйгээр төсөөлөх аргагүй” гэжээ. Алексей Толстой “Шүүмжлэл бол урлагийн уураг тархи мөн” гэсэн байна. Ингэхлээр хэдийгээр хүссэн ч гэлээ урансайхны шүүмж гэгчийг хаяж гэж, алга болгож, устган үгүй хийж болдоггүй зүйл юм байна. Б.М Бернштейн “Шүүмжлэл гэгч нь урансайхны соёлыг удирдах, чиглүүлэх, тогтворжуулагч механизмын нэг юм” гээд үндсэн зорилгыг нь “Урлагийн тайлбарлал, утга нэвтрүүлэгч, дэлгэрүүлэгч юм. Сурталчлан тунхаглахад туслах нийгмийн хяналт юм” гэж тодорхойлжээ. Ийм санааг содон шинжээч С.Энхбаяр зөвшөөрчээ. Өнөөдрийн реалист бус урсгалын гол төлөөлөгч, шүүмжлэгч Г. Аюурзана “Шүүмж хэрэгтэй юу? үгүй юу” гэж ярих нь угаасаа мунхаг харанхуй явдал. Аль ч үеийн урлаг, утга зохиолын шүүмж амин чухал байсан. Шинэ ба нэн шинэ үеийн театр ч бүр амин чухал тавигдаж байна. Урлагийг ардчилах үйл явц шүүмжгүйгээр ахихгүй. Ардчилна гэдэг маань аль болохуйц олон хүнд хүргэнэ гэсэн үг. Олныг сэхээрүүлж гэгээрүүлэхийн тулд өргөн хэмжээнд тайлбарлаж таниулах ёстой. Үүнд л орчин үеийн урлагийн шүүмж, судлалын гол зорилго оршино” гэжээ.

Өнөөдөр шүүмжийг ямар чиглэлээр хөгжүүлэх вэ? Өнгөрсөн нийгмийн үеийн ойлголтууд цэгцэрч, учраа олж байна. Хөгжлийн өөр өөр чиглэлд орж, дүрээ хувиргаж, дахин шинээр төрж байна. Судлаачдын бичсэнийг үзвэл урансайхны шүүмж хэрэггүй, түүнийг нийгмийн шуугиан дунд живүүлж алга болгох хэрэгтэй, утга зохиолын хөгжил болоод зохиолчдод саад болж байна гэсэн зүйл лав л сүүлийн 20 гаруй жил мэдэгдсэнгүй. Урансайхны шүүмж ховордохоор “Утга зохиол гал тогооны хов жив,

мэдэмхий чалчаа яриа” өрнөж, энэ талаархи халуун дотно яриа хумигдан, дайрал давшил, атаархал цуурхал гудамжинд хөглөрдөг юм байна. Авъяас чадалгүй нь ааглах, авъяастай нь хохирох, хийгээгүй нь хожих, хийсэн нь адлагдах явдал гардаг юм байна. Уралдаан тэмцээн, үнэлгээ, шагнал ч учир утгаа алддаг юм байна. Жаахан шүүмжлэх гэвэл “Би ингэж бодож байна, би ингэж харж байна, би ингэж мэдэрч байна, би бусдад заавал таалагдах албагүй, намайг ойлгох ганц хоёр хүн хэрэгтэй, чиний бодол надад хамаагүй” гэх хэдхэн үгээр л ам таглана. Хагас дутуу хэлээр өрнөдөөс хуулбарлагчид янз бүрийн юм ярина. Утга зохиолын үнэ цэнийг ойлгохоо болив.

Бас “захиалгын шүүмж” гэгч бий болж өөрсдийгөө магтуулах, пиардах явдал цэцэглэжээ. Аюултай нь зохиолч хохирохгүй их утга зохиол хохирч, энэ хооронд уншигчид самууран төөрөлддөг аж. Учрыг мэдэхгүй хүмүүс “Одоо ийм л болсон юм байлгүй, өнөө үед ингэж ойлгох ёстой юм байлгүй” гэх болжээ. Өөр нэг юм бол шинэчлэгчийн дүрд тоглогчид юм. Түүнийг л зөв гэхгүй бол хуучинсаг үзэлтэнд орно гэх маягийн ичингүйрлээс үнэн биш, зохиомол, хуурамч, бялбанч амьтдыг төрүүлжээ. Модернизм, постмодернизм гэгчийг цөөн хүн ойлгож, ганц хоёрхон хүн л юм хийж байх шиг байна. Бусад нь хэлбэрдэн дуурайгчид. Утга зохиол руу тэмүүчлэгчид уншигчид цөөрч, түүнээс дайжин холдогсод олшрох төлөвтэй. Ийм маягаар нэг хэсэг явбал бие биеэ ичгүүргүйгээр дуурайж байгаа нийтийн дуу, шүлэг хоёр мөхөж магадгүй нь. Шүлэг зохиол ер нь юунд, хэнд хэрэгтэй юм гэх нь ч үзэгдэнэ.

Сайн шүүмж цөөвтөр гарч буй ч, шүүмжлэл ихэнхдээ голч байж чадсангүй. Туйлширч, нэг талыг барьсан, өөрийн хувийн үзлийг тулгасан, сэтгэлийн хөөрлөөр үгүйгэсэн, хэт мэдэмхийрсэн, хэт баруунжсан, америкжсан үзэл давамгайлах болов. “Философийн өвчигнөл” гаарч, хүн бүр философич болох шахав. Өрнөдийн аль нэг хоцрогдоод улиг болсон ч бай, шинээр гарч ирээд учир зүйг олохгүй нийтэд хүлээн зөвшөөрөгдөөгүй ч бай тэр л хамгаас чухал философи гэх нь байна. Монголчууд “философийн гуйланчлал”-д орж, хормойгоо тосож, хэнээс ч гуйхааргүй, царайчлахааргүй эртнээс нааш агуу их гүн ухааныг дэлхийн сэтгэлгээнд оруулж чадсан мэргэдтэй ард түмэн. Монголын уламжлал гэхээр юм, нүүдэлчдийн онцлогтой гэхээр юм, үндэсний сэтгэлгээгээр хандсан юм бүхэн хоцрогдол, шившиг мэт яригдах болов. Монголыг монгол биш болгох энэ буруу үзэлд залуус ихээр оосорлогджээ. Нүүдэлчдийн ухаан, оюун санаа хоцрогдоно гэж байдаггүй, гэрийн бууриа солих бүр, нэгэн өвөл, нэгэн зун өнгөрөх бүр, нэгэн үдэш нэгэн одыг таних бүр оюун ухаан шинээр сэлбэгдэн шинэчлэгдэж, буурайгаасаа үг сонсох бүр ухаажиж, бусдын хараагүйг харж, нээгээгүйг нээдэг. Ер нь мал дагасан амьдрал тэр чигээрээ амьдралын гүн ухаан, од гариг, хорвоо ертөнцийн учир шалтгаалцал, нууц тайлал, мэргэн цэцэн үг хэллэг, зөрчил бэрхшээл дундаас олж мэдсэн өөрийн эгэл хар гэхдээ шалгармал бодол ухаан байдаг.

Утга зохиолын онол уран сайхны шүүмж хоёр салшгүй нягт холбоотой. Онол нь шүүмжээ хөгжүүлж байдаг, шүүмж нь ч бас онолоо хөгжүүлэх үндэс болдог ийм харилцан хамааралтай. Өнгөрсөн үед ганцхан социалист реализмын аргаар бүхнийг тайлбарлаж байсан болохоор утга зохиолын онол явцуу байсан бол, өнөөдөр янз бүрийн онол яригчид олширч, шүүмж нь байхгүй болсон нь ажиглагдаж байна. Зохиолч огт өөрийг бодож бичсэн байхад шуудхан л социалист реализмын уут руу хүчээр оруулаад чихчихдэг байсан явдал Д.Нацагдоржийн судлалд ч бий.

Ер нь уран сайхны шүүмж, шүүмжлэлийг шинэ утгаар авч үзэх ёстой болжээ. Хуучны ойлголтоор бол “шүүмж, шүүмжлэл” гэвэл заавал өрөөсгөл талаас харахыг

хичээж, мушгин гуйвуулах, заавал муу үгийг хэлэхэд хүргэж байв. Одоо утга зохиолын шинжээч, урансайхны герменевтикч, урансайхны тайлал зүйч, утга зохиол судлаач гэж нэрлэмээр байгаа юм. Ерөөсөө утга зохиол шүүмжлэгч гэдэг үгийг “**утга зохиолын шинжээч**” гэж нэрлээд хэвшүүлчихмээр. Ямар ч байсан социализмын үеийн “шүүмжлэгч” гэдэг нэр түүнтэйгээ хамт алга болоход болохгүй гэх газаргүй. Тэгвэл “Шүүмж алга болсонд” баяр хүргэсэн сэтгэлийн бачуурал бас хамт алга болох биз.

Тэгвэл урансайхны шүүмжлэлд юу орж ирэх вэ гэвэл социалист реализмын оронд герменевтикийн тайлал зүйн онол сэлбэн орж ирэх нь шүүмжлэлийн агаарыг шууд цэвэршүүлнэ. Ер нь утгазохиолын тайлал зүй ЯАГААД? гэсэн асуултыг өөртөө тавьдаг, түүнд хариулаач гэж шаарддаг. Тэгээд цаад учир шалтгаан, мөн чанарыг ухан гаргаж, цэг тэмдгийг хүртэл тайлах шаардлагатай болно. “Дотор нь орно” гэдэг шиг утга зохиолын маш нарийн үзэгдлүүд, тархины хэдэн сая живаа ухамсартай хийгээд ухамсаргүйгээр буусан үйлдэл дотор, гүн чинад оршсон бүхэнд нэвтэрч, шинээр мэдэрч, шинээр таньж, шинэ оюун дүгнэлт гаргаж, тайлагдахын аргагүйг итгэл үнэмшилтэй тайлж, зөвхөн магтах бус, бас муулах биш учрыг тайлан дүгнэх явдал юм. Яагаад сайн гэв? Яагаад муу гэв?, яагаад шинэ үзэгдэл гэв? Яагаад хуучин хоцрогдсон гэв? Гэдгийн учир тайлагдаж, тайлбарлаж ойлгуулахдаа оршдог. Герменевтика гэдэг ойлголт философи суурьтай онол судалгааны арга. Сүүлийн үед утга зохиол туурвигчийн болон туурвилзүйг тайлан шинжлэхэд гүн гүнзгий нэвтэрч байна. Христосын “Библи” судрыг дэлхийн утга зохиолын анхдагч гэж бичсэн нь ч тааралддаг. Хэдэн мянган жилийн өмнө зохиогдсон түүнийг сурталчлагчид, номлогчид үеийн үед ёстой ”гэдэс дотрыг шувтрах” шиг тайлбарлаад ч, түүний хязгаарт хүрэхгүй байна. Тэрхүү тайлал ном хэдэн сая хувиар нийтлэгдэж байна.

Ингэж учирзүйг олсон тайлалзүй л өнөөгийн шүүмжийг аварна. Утга зохиолын задлан шинжлэлийн арга зүй шинэчлэгдэж, түүнд алдагдсан нэр хүндийг эргүүлж авчирна. Монголчууд аливааг шинжихдээ дадамгай. Морь шинжээчид хурдан морины хэдэн зуун шинжийг нээжээ. Түүн лугаа адил утгазохиолын шилдэг тайлагчид цөөнгүй төрнө.

Манай ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн “ХХ зууны монгол зохиолчид” цуврал нь ихээхэн зөв, эрдмийн санаачилга, сэдэл болсныг хэлэх хэрэгтэй. Харин хаалгыг нь чанга бариагүйгээс өнгөрсөн зуунд өв уламжлал, үнэт зүйлсээ үлдээж чадаагүй дундач гэхээр зарим зохиолч, шүлэгчийг оруулсан нь урам хугарахад хүргэсэн юм. Цензур зохиол бүтээлд шаардлагагүй ч, шалгуур үзүүлэлтэд цензур хэрэгтэй. Бас манай судлаач шүүмжлэгчдийн хийж буй тайлал зүй үнэхээр учир дутагдалтай харагдсан юм. Нэгд судлаад бичих хугацаа их давчхан байсан байх, Хоёрт: зохиолч болоод зохиолын дотор нь орж чадахгүй нөгөөх нь хуучны хэвшсэн аргаар гаднаас өнгөцхөн ханддаг, хуурай хоосон магтдаг арга барил салаагүйг харуулсан, Гуравт: захиалгын юм бол захиалга шүү дээ, тиймээс жинхэнэ сэтгэлээсээ хандаагүй Дөрөвт: хэнийг хэнээр хийлгэх вэ? ямар судлаач, шинжээчийг зохиогчоор оруулах вэ? гэдэг бодлого байхгүй байснаас утга зохиолын бараг мэргэжилгүй хүнээр хүртэл бичүүлсэн нь харагдсан. Манайд жинхэнэ тайлал зүйн аргаар байнд нь тун дөхүүлж хийсэн бүтээл бол эрдэмтэн нэрт шүүмжлэгч, судлаач Бажуудайн Ганбатын “Тунгалаг Тамир” романд хийсэн судалгаа юм. Энэ бүтээлээр чухам Ч.Лодойдамба гэж хэн бэ? түүний ертөнц гэж юу байв? гэдгийг нээж чадсан, “Тунгалаг Тамир” роман яаж бүтснийг нээж чадсан, зохиолын жижиг сажиг хэсэг, зан заншил, үг хэллэг, баатрын доторхи сэтгэлийг нээж чадсан, дээр нь бас нэмээд хэлэхэд шүүмжлэгч нарт нэн дутагдаад байдаг эвлэг

найруулга, дүрэлзсэн санааны талаар гоц чадвартан гэдгээ харуулж чадсан загвар жишээ болох бүтээл болсон юм. Харамсалтай нь ид бүтээх туурвих үедээ Б.Ганбат маань ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн нь нэн харамсалтай, нөхөж баршгүй гарз болсон юм.

Утга зохиолын шинжээчдийн ур чадвар ерөөсөө зохиолоо дээд зэргээр ойлгож, түүндээ тулгуурлан хийсэн тайлал, тайлбар нь эмч өвчнийг оношлохтой адилаар бүхэлд нь задалж, задалснаа нэгтгэж, өөр юмстай харьцуулж, эх бичлэгт нээлт хийж бичих нь чухал болжээ. Утгазохиолын шинжлэлийн үр дүнг олонд хүргэхийн тулд зохиолчийн адил үгийн урлаг хэрэгтэй. Хуурай ухуулан сэнхрүүлэх үүрэг хэрэггүй болж. Зохиолчдод, уншигчдад, сонирхогчдод хэрэгтэй түлхүүр дүгнэлт ихээхэн чухал төдийгүй энэ л утга зохиолын соён гэгээрүүлэх тал нь юм. Өөрийнхөөрөө зүтгэдэг хүн ч “Юу билээ энэ чинь” гэхээр шүүмж тайлалын нэг үг, өгүүлбэр ч үнэ цэнтэй.

Монголынхоо 90-ээд оноос хойших, шинэ зууны утга зохиолын өнөөгийн чиг хандлага, өнгө төрхийг тодорхойлох боломжтой цаг үед тулж иржээ. Үүнийг хийх эзэд бол сайн чадварлаг, бүх талын мэдлэг боловсролтой, гадаад дотоодын ном зохиол ихийг уншиж, гэгээрсэн, сайн, муу, сайхан, муухайг таньж ухаарсан сайн шинжээч, судлаачид юм. Шинжээчийн сэтгэлгээ түрүүлж явбал уранзохиол алхам алхмаар урагш явна. Юу хэлдэггүй, шинээр нээдэггүй шүүмж шинжлэл байснаас байгаагүй нь дээр, яагаад гэвэл тэр хөгжилд саад тотгор болдог. Шилдэг шүүн тунгаагчаа дагаж өсөж өндийх үе бий. Гарсныг тайлбарлах биш, гараагүйг, гарах ёстойг урьдаас хэлчихдэг бол ёстой жинхэнэ мах цусанд төрсөн шинжээч мөн. Үгийн утгын мэлмийг нээгчид бол уран сайхны шинжээчид. “Уран зохиолын шүүмжлэл гэдэг бол шинжлэх ухаан урлаг хоёрын нийлбэр юм” гэдэг онол хэдий үед ч хуучрахгүй. Монголын уран зохиолд дэвшил, уналт, ухралт, уламжлал шинэчлэл бишгүй л боллоо. Дэлхийн утгазохиолын чиг хандлагаас хол хоцроогүй. Угийн сэтгэгч ард түмний үр сад яаж хоцрохов? Даацтай том шинэчлэл гарав уу? бид юугаараа дутуу явна? Цаашид яах ёстой вэ? гэдэгт хариу хүлээсэн хэвээр байна. Манайд ер нь даац, гүн ухаарал, онож хэлсэн үнэлгээ, ер бусын сэтгэмж сэрэл л дутдаг.

Уран сайхны шүүмжлэл ерийн нэг сэтгэдэл биш, хувийн үзэмж бус, цэвэр бие даасан чөлөөт, хэнээс ч хараат бус, ёс зүйтэй, хариуцлага нэхсэн оюун санааны хүнд төвөгтэй, онцгой авьяас, үнэнийг хэлэх зориг зүрх шаардсан өвөрмөц сэтгэлгээ юм. Тийнхүү утга зохиолын цэгнэл улам ухаалаг, улам өргөн цар хүрээтэй, улам өгөөжтэй, тэнүүн агуу ертөнц болно. Залуу шүүмжлэгчид өөрсдийн дуу хоолойгоор үнэнээрээ, өөрийнхөөрөө гарч ирэх цаг болжээ. Шүүмжлэл уншигч, зохиолч хоёрын аль алиныг хүмүүжүүлэх чухал хэрэглүүр мөн. Ухааруулах, гэгээрүүлэх, мэдрүүлэх, таниулах ертөнц. Шүүмжлэл ганц нэг хүний дүр хүсэл, жигшил зэвүүцэл биш, олны оюуны боловсролын эрх ашигт үйлчлэх үйлч. Хэн нэгнээс өшөө хорсол авч, бачуурсан сэтгэлийн цэнгэлийг эдэлж таарамгүй.

Бид өнгөрсөн үед ганцхан үзэл сурталжсан тэрхүү реализмд хөтлөгдөж байлаа. Одоо жинхэнэ сонгодог реалистууд, жинхэнэ содон постмодернистууд төрөх цаг болж. Зохиолч л муу болохоос бус муу муухай арга гэж байхгүй. Муу дутуу зэрэдэг бичиж байгаагаас зарим шинэ урсгал аргыг муухай харагдуулж байна. Магадгүй зохиолч болгон өөрийн реализмтай, бас өөрийн модернизмтай. Бид гэнэн реализмаас салах нь

зүй, бас анархист модернизмаас ч салах нь зүй. Утга зохиол ухаажсан цагт нийгэм ухаажина.

“Миний нүдээр хардаг ч болоосой” гэж зохиолч бүр, найрагч бүр халагладаг. Тэгвэл тэднээс ч илүү холыг харах хэрэгтэй юм. Зохиолчдод өөрөө ч ойлгоогүй, таниагүй, нээгээгүй юмс бишгүй байдаг. “Би чамаас өөрийгөө олж харлаа. Тийм бодол санаа надад ер орж байгаагүй” гэх зохиолч тааралддаг. Юмыг олон талаас нь харвал, олон л харагдана, ганцхан талаас нь харвал ганцхан л харагдана. Шүүмжлэл, цэгнэхүй, шинжихүй, танихуй гэдэг бол утга зохиолын ертөнц дотор хамгийн дээд оргил гэж болохоор өндөрлөг юм. Тэр өндөрлөгт авирч чадах, үнэмшүүлж чадах, итгэл хүлээсэн тийм урансайхны шинжлэл хэзээ ирэх вэ? Утга зохиолын шинжээчид жинхэнэ уран бүтээлч, жинхэнэ шинжлэх ухаанч, жинхэнэ тайлагч, жинхэнэ гүн ухаантан, жинхэнэ утга зохиолын том бодлоготон, жинхэнэ үндэсний том соён гэгээрүүлэгч болсон цагт манай утга зохиол дэлхийн тавцанд гарч ирэх нь дамжиггүй.

*Бээжин, Төвийн үндэстний Их сургууль
2012. 09. 16-18*

SUMMARY

How must we advance literary criticism? Concepts from the past are becoming organized and understandable. Old ideas are joining up with new lines of development, changing their forms, and being revived. Looking at scholars' writings from the past 20 years we do not see anyone arguing that literary criticism is unnecessary, that it should be allowed to drown and disappear in the chatter of society, or that it hinders the development of literature and writers. The decline of real literary criticism leads to the spread of “literary kitchen gossip and pedantic chatter”, the loss of warm and close discussions of literature, and the spread of jealous gutter attacks among critics. The untalented brag, the talented suffer, the lazy succeed, the diligent lose out. Literary competitions, ratings, and prizes lose all meaning. The critic's opinion means nothing to the author: “This is what I think, this is what I see, this is what I feel; I have no need to please others; it is enough to me if only one or two others understand my work; your opinion matters nothing to me”. Authors who imitate Western writers without understanding them make grand claims. No one understands the value of literature today.